



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 12 сарын 05 өдөр

Дугаар А/740

Арвайхээр

Сургалтад оролцуулах тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 02/01 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “БҮТЭЭЛЧ-ӨВӨРХАНГАЙ-2020” хөтөлбөрийн 4.1.5.2, аймгийн Засаг даргын 2017 оны а/525 дугаар захирамжаар батлагдсан “Төрийн албан хаагчийн сургалт-хөгжил” хөтөлбөрийн 4.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Солонгос улсын Пусан хотод 2019 оны 12 дугаар сарын 15-20-ны өдрүүдэд зохион байгуулагдах сургалтад оролцох төлөөлөгчдийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Сургалтад оролцогчдыг нэгдсэн зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн (Э.Бадамгэрэл)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

01101399

Аймгийн Засаг даргын 2019 оны 12
дугаар сарын 25 ны өдрийн 4710 дугаар
захирамжийн хавсралт

СУРГАЛТАД ОРОЛЦОХ ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
БҮРЭЛДЭХҮҮН

№	Төлөөлөгчдийн нэрс	Албан тушаал
1	Элбэгийн Бадамгэрэл	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
2	Чулуунбатын Батсуурь	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр хариуцсан ахлах мэргэжилтэн
3	Сүрэнжавын Ганчимэг	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн газар, байгаль орчин, аялал жуулчлалын бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн
4	Лантуугийн Ишханд	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн бодлогын баримт бичиг, дотоод аудит хариуцсан ахлах мэргэжилтэн
5	Ренчинхорлоогийн Цэрэндэжид	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн төсвийн зарлагын ахлах мэргэжилтэн
6	Дүгэрсүрэнгийн Мөнхцэцэг	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн хүний эрх, авлига, ашиг сонирхлын зөрчлийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
7	Баярсайханы Өлзийбаяр	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын тоо бүртгэлийн офицер